



САНГИЙН САЙД
З.МЭНДСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.06.18 № 36

Орон нутгийн хөгжлийн сангийн
үйл ажиллагааны талаар

Төсвийн төвлөрлийг сааруулах, орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого хэрэгжүүлсэн боловч Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт, үр ашиг, ил тод байдал, иргэдийн оролцооны талаар олон нийтийн шүүмжлэл нэлээдгүй гарсаар байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаар дараах асуулгыг Танд тавьж байна.

1.2006 оноос хойш Орон нутгийн хөгжлийн санд улсын төсвөөс жил бүр аймаг, нийслэл, сум, дүүрэгт хуваарилсан хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээлэл;

2.2006–2026 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл, арга хэмжээний тоо, үүнээс ашиглалтад ороогүй, дутуу хэрэгжсэн, чанарын шаардлага хангаагүй, аудитын зөрчилтэй гэж тогтоогдсон төслүүдийн тоон мэдээллийг аймаг, сум тус бүрээр;

3.Үндэсний аудитын газар болон бусад хяналтын байгууллагаас ОНХС-ийн зарцуулалттай холбоотой гаргасан дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл;

4.Тус сангийн хөрөнгийг хуваарилах аргачлал, шалгуур үзүүлэлтүүд 2006 оноос хойш хэдэн удаа, ямар үндэслэлээр өөрчлөгдсөн талаарх тайлбар;

5.Иргэдийн оролцоонд тулгуурлан төсөл, арга хэмжээг эрэмбэлэх тогтолцоо бодитой хэрэгжиж байгаа эсэх талаар үнэлгээ хийсэн эсэх, үнэлгээний дүгнэлт;

6.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны болон ашиг сонирхлын зөрчил, хууль бус зарцуулалтын талаарх мэдээлэл, түүний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар;


2026000104

7.ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, үр дүнг олон нийтэд ил тод мэдээлэх цахим системийн өнөөгийн нөхцөл байдал, хүртээмж, хяналтын талаарх мэдээлэл болон цаашид иргэдийн бодит оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлэх бодлого, эрх зүйн шинэчлэлийн талаарх мэдээлэл.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б.УЯНГА

2026000104